



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2023 оны 12 сарын 13 өдөр

Дугаар 655

Улаанбаатар хот

“Монголын цахилгаан холбоо” хувьцаат компани
нэмэлт хувьцаа гарган, хөрөнгийн биржээр
олон нийтэд нээлттэй арилжих тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, 21 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг, 56 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Улсын Их Хурлын 2022 оны 16 дугаар тогтоол, Засгийн газрын 2022 оны 244 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монголын цахилгаан холбоо” хувьцаат компанийн 25,870,276 (хорин таван сая найман зуун далан мянга хоёр зуун далан зургаа) ширхэг энгийн хувьцаа дээр 11,249,855 (Арван нэгэн сая хоёр зуун дөчин есөн мянга найман зуун тавин тав) ширхэг энгийн хувьцааг нэмж гаргаж, хөрөнгийн биржээр дамжуулан олон нийтэд нээлттэй санал болгосугай.

2. Олон нийтэд санал болгох нэгж хувьцааны үнийг 500 (таван зуун) төгрөгөөр тогтоосугай.

3. Энэхүү тогтоолын 2 дахь заалтыг мөрдлөг болгон ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж буй гишүүдэд удирдамж болгосугай.

4. “Монголын цахилгаан холбоо” хувьцаат компанийн хувьцааг хөрөнгийн биржээр арилжих үйл ажиллагааг Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржээс баталсан журмын дагуу зохион байгуулахыг “Монголын цахилгаан холбоо” хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (Ц.Баяр-Эрдэнэ), Гүйцэтгэх захирал (Б.Чинбат) нарт зөвшөөрсүгэй.

5. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

123006816
34-r huraldaan.docx